**МОНГОЛ УЛСЫН**
**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН**
**ТУШААЛ**

2019 оны 11 сарын 29 өдөр Дугаар А/540 Улаанбаатар хот

Журам, шалгуур үзүүлэлт, жагсаалт
батлах тухай

Монгол Улсын Засгийн Газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4, 16.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сумын эрүүл мэндийн төвийн зэрэглэл, бусад сумын хүн амыг хамруулан тусламж, үйлчилгээ үзүүлэх зарим сумын эрүүл мэндийн төвийн үйлчлэх хүрээг тогтоох, багийн эмчийн салбар байгуулах, өөрчлөн зохион байгуулах тухай журмыг нэгдүгээр, Сумын эрүүл мэндийн төвийн зэрэглэлийг тогтооход ашиглах шалгуур үзүүлэлтийг хоёрдугаар, сумын эрүүл мэндийн төвийн зэрэглэлийн жагсаалтыг гуравдугаар хавсралтаар тус тус батлагсугай.

2. Энэхүү тушаалыг хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Бодлого төлөвлөлтийн газар (Р.Оюунханд), Эмнэлгийн тусламжийн газар (Я.Буянжаргал), Эрүүл мэндийн хөгжлийн төв (Б.Нарантуяа) –д тус тус даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн Эрүүл мэндийн газрын дарга нарт үүрэг болгосугай.

4. Сум дундын эмнэлэг нэртэй ажиллаж байсан сумын эрүүл мэндийн төвүүдийн санхүүжилтийг 2021 оноос эхлэн орон нутгийн төсөвт шилжүүлэх асуудлыг шийдвэрлэхийг Эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын газар /Г.Эрдэмбилэг/-т үүрэг болгосугай.

5. Тус тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын Сум дундын эмнэлэг байгуулах тухай 2003 оны 114, Сумдын эмнэлгийн статусыг өөрчлөх тухай 2011 оны 292, Сум дундын эмнэлэг байгуулах тухай 2013 оны 256 дугаар тушаалыг тус тус хүчингүйд тооцсугай.

6.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Я.Амаржаргалд даалгасугай.

САЙД Д.САРАНГЭРЭЛ

081844

Эрүүл мэндийн сайдын 2019 оны
...11... сарын ..29... өдрийн А/540
дүгээр тушаалын ..1...- р хавсралт

**Сумын эрүүл мэндийн төвийн зэрэглэл, бусад сумын хүн амыг хамруулан тусламж, үйлчилгээ үзүүлэх зарим сумын эрүүл мэндийн төвийн үйлчлэх хүрээг тогтоох, багийн эмчийн салбар байгуулах, өөрчлөн зохион байгуулах журам.**

**Нэг. Нийтлэг үндэслэл.**

1.1 Энэхүү журмыг хөдөөгийн хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх сумын эрүүл мэндийн төвийн хүрээг тогтоох, багийн эмчийн салбар байгуулах, өөрчлөн зохион байгуулахтай холбоотой харилцааг зохицуулахад дагаж мөрдөнө.

1.2 Харъяа нутаг дэвсгэрт ажил эрхэлж байгаа иргэд, отор нүүдлээр явж буй малчид болон аялал, жуулчлалаар явж байгаа иргэдэд "Хэнийг ч орхигдуулахгүй байх" зарчмыг баримтлан тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

1.3 Сумын эрүүл мэндийн төвүүд нь газар нутгийн байршлын хувьд ойролцоо оршиж байгаа зэргэлдээх сумын хүн амд болон иргэн өөрөө сонгож үйлчилгээ авахыг хүссэн тохиолдолд тусламж, үйлчилгээг харъяалал харгалзахгүй үзүүлнэ.

**Хоёр. Сумын эрүүл мэндийн төвийн зэрэглэлийг тогтоох**

2.1 Сумын эрүүл мэндийн төвийн зэрэглэлийг тус тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан шалгуур үзүүлэлтийг харгалзан тогтооно.

2.2 Сумын эрүүл мэндийн төвийн зэрэглэлийг шалгуур үзүүлэлтийг дараах байдлаар үнэлнэ.

2.2.1 хүн амын тоо, байршил, замын бартаанаас хамаарсан шалгуур үзүүлэлтийг үнэлэхдээ алслалт, үйлчлэх хүрээний радиус, замын бартаанаас хамаарсан индексийг Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн төсвийг тооцох аргачлалд заасан индексээр тооцно.

2.2.2 тусламж, үйлчилгээтэй холбоотой шалгуур үзүүлэлтийг сүүлийн 3 жилийн эрүүл мэндийн статистик үзүүлэлтийн дундажаар тооцно.

2.2.3 тусгай шалгуур үзүүлэлтийг онооны нийлбэрээр тооцох ба тусгай шалгуур үзүүлэлтэд хамаарах үзүүлэлт байхгүй бол оноо тавихгүй.

2.3 Шалгуур үзүүлэлтийн нийлбэр онооноос хамааруулан сумын эрүүл мэндийн төвийг А", "Б", "В" зэрэглэлд ангилна.

2.3.1 Шалгуур үзүүлэлтийн нийлбэр оноо 40±4 түүнээс дээш байвал "А" зэрэглэл

2.3.2 Шалгуур үзүүлэлтийн нийлбэр оноо 31±4 байвал "Б" зэрэглэл

2.3.3 Шалгуур үзүүлэлтийн нийлбэр оноо 27 ба түүнээс доош байвал "В" зэрэглэл

2.4.1 Сумын эрүүл мэндийн төвийн "А" зэрэглэлд өөрийн сумын иргэдэд өрхийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхээс гадна зэргэлдээх сумын хүн амд 4-өөс доошгүй үндсэн мэргэшлийн тусламж үйлчилгээг үзүүлэх чадавхи бүхий сумын эрүүл мэндийн төвүүд хамаарна.

2.4.2 Сумын эрүүл мэндийн төвийн "Б" зэрэглэлд улсын хилийн дагуу болон улсын чанартай автозам, төмөр зам дагуу байрласан, осол гэмтлийн онцгой бүс, уул уурхай, үйлдвэрлэл, аялал жуулчлал хөгжсөн бүс нутгийн сумын эрүүл мэндийн төвүүд хамаарна.

2.4.3 Сумын эрүүл мэндийн төвийн "А" болон "Б" зэрэглэглэлд хамрагдаагүй бусад бүх сумын эрүүл мэндийн төвүүд "В" зэрэглэлд хамаарна.

2.5 Орон нутгийн нөхцөл байдалтай уялдуулан сумын эрүүл мэндийн төвийн зэрэглэлийг аймаг тус бүрээр гаргана.

2.6 Эрүүл мэндийн газар нь "А" зэрэглэлийн сумын эрүүл мэндийн төвд үндсэн мэргэшлийн тусламж үйлчилгээ үзүүлэх тойргийн сумдын хуваарийг батална.

2.7 Орон нутгийн хөгжил, бүтээн байгуулалт, суурьшлын бүс байгуулагдсан, улсын чанартай автозам, төмөр зам шинээр тавигдсан, төвийн тусламж, үйлчилгээний хүртээмж, чанарт дэвшил гарсан тохиолдолд сумын эрүүл мэндийн төвийн зэрэглэлд өөрчлөлт оруулах саналыг Эрүүл мэндийн яаманд ирүүлнэ.

2.8 Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн төсөв нь Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, тэдгээрийг дагаж гарсан тушаал, тогтоол, шийдвэрээр зохицуулагдана.

## Гурав. Багийн эмчийн салбар байгуулах, өөрчлөн зохион байгуулах

3.1 Багийн эмчийн салбарыг байгуулах, өөрчлөн зохион байгуулахдаа Эрүүл мэндийн яаманд албан бичгээр мэдэгдэж, зөвшөөрөл авна.

3.2 Багийн эмчийн салбарыг хүн ам нь багийн төвдөө суурьшин байршсан, төрийн захиргааны нэгжтэй, сургууль, цэцэрлэг, банк зэрэг төрийн үйлчилгээний байгууллагатай газарт байгуулна.

3.3 Багийн эмчийн салбарыг хилийн боомт, уул уурхай болон аялал жуулчлалын улмаас хүн ам олноор зорчдог газар нутагт тухайн үйл ажиллагаа явуулж буй байгууллагын дэмжлэгтэйгээр байгуулж, хамтран ажиллаж болно.

3.4 Багийн эмчийн салбар нь сумын эрүүл мэндийн төвийн удирдлага дор, нэгдсэн санхүүжилттэй байна.

3.5 Багийн эмчийн салбарт бага эмч ажиллах ба тухайн сумын эрүүл мэндийн төвийн хүний нөөцийн боломжоос шалтгаалан их эмч ажиллуулж болно.

3.6 Багийн эмчийн салбарт орон нутгийн хөгжлийн сангаас дэмжлэг үзүүлж ажиллана.

Эрүүл мэндийн сайдын 2019 оны
...11... сарын ...29... өдрийн ...А/540
дүгээр тушаалын ...2...- р хавсралт

# СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ЗЭРЭГЛЭЛИЙГ ТОГТООХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

| | Үзүүлэлт | Оноо | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| ***1-р бүлэг .Хүн амын тоо, байршил, алслалт, замын бартаанаас хамаарсан* шалгуур үзүүлэлт** | | | | | | | |
| 1. | Хүн амын тоо | 2000 | 2001-3000 | 3001-4500 | 4500-6000 | 6000-7500 | 7500 дээш |
| 2. | Алслалтаас хамаарсан индекс | 0.5 | 0.51-1.0 | 1.1-1.5 | 1.6-2.0 | 2.1-2.5 | 2.6 |
| 3. | Үйлчлэх хүрээний радиусаас хамаарсан индекс | 0.5 | 0.51-1.0 | 1.1-1.5 | 1.6-2.0 | 2.1-2.5 | 2.6 |
| 4. | Замын бартаанаас хамаарсан индекс | 0.49 | 0.5-0.8 | 0.81-1.0 | 1.1-1.3 | 1.4-1.6 | 1.7 |
| ***2-р бүлэг. Тусламж үйлчилгээтэй холбоотой шалгуур үзүүлэлт*** | | | | | | | |
| 1. | Хэвтэн эмчлүүлэгчийн тоо | 200 | 201-300 | 301-400 | 401-500 | 501-600 | 601 дээш |
| 2. | Амбулаторийн үзлэгийн тоо | 2000 | 2001-4000 | 4001-6000 | 6001-8000 | 8001-10000 | 10001 дээш |
| 3. | Төрөлтийн тоо /огт төрөлтгүй бол-0/ | 10 хүртэл | 11-20 | 21-30 | 31-40 | 41-60 | 61 дээш |
| 4. | Мэс заслын тусламж /огт хийгээгүй бол-0/ | 5 хүртэл | 6-10 | 11-20 | 21-30 | 31-40 | 40 дээш |
| 5. | Дуудлагын тоо | 200 | 201-400 | 401-600 | 601-800 | 801-1000 | 1000 дээш |
| 6. | Осол гэмтлийн тохиолдлын тоо | 10 хүртэл | 11-30 | 31-50 | 51-70 | 71-100 | 101 дээш |
| ***3-р бүлэг.Тусгай шалгуур үзүүлэлт*** | | | | | | | |
| 1. | Улсын чанартай автозам, төмөр зам дагуу байрласан эсхүл төмөр зам, автозам шинээр баригдахаар төлөвлөгдсөн, осол гэмтлийн онцгой бүс | Сумын газар нутаг дээгүүр дайран өнгөрсөн бол - 5 оноо<br>Осол гэмтлийн онцгой бүст хамаардаг бол – 5 оноо | | | | | |
| 2. | Улсын хилийн дагуу байрласан | -Улсын хилийн дагуу байрласан бол -3 оноо<br>- Хилийн боомттой, байнгын ажиллагаатай бол - 6 оноо<br>- Хилийн боомттой, улирлын чанартай ажилладаг - 4 оноо | | | | | |
| 3. | Хилийн цэргийн отряд | Хилийн цэргийн отряд, заставтай бол - 4 оноо | | | | | |
| 4. | Аялал, жуулчлалын бүс нутаг | - Аялал, жуулчлалын бүс нутаг бол - 4 оноо | | | | | |
| 5. | Уул, уурхайн бүс нутаг | -Уул, уурхайн олборлолт /байнгын ажиллагаатай/-6<br>-Уул, уурхайн олборлолт /улирлын чанартай/-4 | | | | | |

Эрүүл мэндийн сайдын 2019 оны
..11.. сарын ...29.. өдрийн А/540
дүгээр тушаалын ..3...-р хавсралт

# СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ЗЭРЭГЛЭЛИЙН ЖАГСААЛТ

| Аймаг | Сумын эрүүл мэндийн төв | Зэрэглэл | | |
|---|---|---|---|---|
| | | А | Б | В |
| **АРХАНГАЙ** | Батцэнгэл | | | + |
| | Булган | | | + |
| | Жаргалант | | + | |
| | Их тамир сум | | + | |
| | Өгийнуур сум | | | + |
| | Өлзийт сум | | | + |
| | Өндөр-Улаан сум | | + | |
| | Тариат сум | + | | |
| | Төвшрүүлэх сум | | | + |
| | Хайрхан сум | | + | |
| | Хангай сум | | + | |
| | Хашаат сум | | | + |
| | Хотонт сум | | | + |
| | Цахир сум | | + | |
| | Цэнхэр сум | | + | |
| | Цэцэрлэг сум | | | + |
| | Чулуут сум | | | + |
| | Эрдэнэмандал сум | + | | |
| | **Дүн** | **2** | **7** | **9** |
| **БАЯНХОНГОР** | Баацагаан сум | | | + |
| | Баянбулаг сум | | | + |
| | Баянговь сум | | | + |
| | Баянлиг сум | | + | |
| | Баян-Овоо сум | | | + |
| | Баян-Өндөр сум | | + | |
| | Баянцагаан сум | + | | |
| | Богд сум | + | | |
| | Бөмбөгөр сум | | + | |
| | Бууцагаан сум | | + | |
| | Галуут сум | | | + |
| | Гурванбулаг сум | | | + |
| | Жаргалант сум | + | | |
| | Жинст сум | | | + |
| | Заг сум | | | + |
| | Өлзийт сум | | | + |
| | Хүрээмарал сум | | | + |
| | Шинэжинст сум | | + | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | Эрдэнэцогт сум | | | + |
| | Шаргалжуут тосгон | | | + |
| | Дүн | **3** | **5** | **12** |
| **БАЯН-ӨЛГИЙ** | Алтай | | + | |
| | Алтанцөгц сум | | | + |
| | Баяннуур сум | | + | |
| | Бугат сум | | | + |
| | Булган сум | | + | |
| | Буянт сум | | | + |
| | Дэлүүн сум | + | | |
| | Ногооннуур сум | + | | |
| | Сагсай сум | | + | |
| | Толбо сум | | | + |
| | Улаанхус сум | + | | |
| | Цэнгэл сум | + | | |
| | Цагааннуур тосгон | | | + |
| | **Дүн** | **4** | **4** | **5** |
| **БУЛГАН** | Баян-Агт сум | | + | |
| | Баяннуур сум | | | + |
| | Бугат сум | | | + |
| | Бүрэгхангай сум | | + | |
| | Гурван булаг сум | | + | |
| | Дашинчилэн сум | | + | |
| | Могод сум | | | + |
| | Орхон сум | | | + |
| | Рашаант сум | | + | |
| | Сайхан сум | | | + |
| | Сэлэнгэ сум | | + | |
| | Тэшиг сум | | + | |
| | Хангал сум | | | + |
| | Хишиг-өндөр сум | + | | |
| | Хутаг-Өндөр сум | + | | |
| | Хялганат тосгон | | + | |
| | **Дүн** | **2** | **8** | **6** |
| **ГОВЬ-АЛТАЙ** | Алтай сум | + | | |
| | Баян-Уул сум | + | | |
| | Бигэр сум | + | | |
| | Бугат сум | | + | |
| | Дарив сум | | | + |
| | Дэлгэр сум | | | + |
| | Жаргалан сум | | | + |
| | Тайшир сум | | | + |
| | Тонхил сум | | + | |
| | Төгрөг сум | + | | |
| | Халиун сум | | | + |
| | Хөхморьт сум | | | + |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | Цогт сум | | + | |
| | Цээл сум | | | + |
| | Чандмань сум | | + | |
| | Шарга сум | | | + |
| | Эрдэнэ сум | | + | |
| | Баянтоорой тосгон | | | + |
| | Гуулин тосгон | | | + |
| | **Дүн** | **4** | **5** | **10** |
| **ГОВЬСҮМБЭР** | Баянтал сум | | | + |
| | Шивээговь сум | | + | |
| | **Дүн** | | **1** | **1** |
| **ДАРХАН** | Орхон сум | | + | |
| | Хонгор сум | | + | |
| | Шарын гол сум | + | | |
| | **Дүн** | **1** | **2** | **0** |
| **ДОРНОГОВЬ** | Айраг сум | + | | |
| | Алтанширээ сум | | | + |
| | Даланжаргалан сум | | + | |
| | Дэлгэрэх сум | | | + |
| | Замын-Үүд сум | | | **НЭ** |
| | Иххэт сум | | + | |
| | Мандах сум | | + | |
| | Өргөн сум | | + | |
| | Сайхандулаан сум | | | + |
| | Улаанбадрах сум | | + | |
| | Хатанбулаг сум | | + | |
| | Хөвсгөл сум | | + | |
| | Эрдэнэ сум | + | | |
| | Зүүнбаян сум | | + | |
| | Дүн | **2** | **6** | **5** |
| **ДОРНОД** | Баяндун сум | | + | |
| | Баянтүмэн сум | | | + |
| | Баян-Уул сум | + | | |
| | Булган сум | | | + |
| | Гурванзагал сум | | | + |
| | Дашбалбар сум | + | | |
| | Матад сум | | + | |
| | Сэргэлэн сум | | | + |
| | Халхгол сум | + | | |
| | Хөлөнбуйр сум | | | + |
| | Цагаан-Овоо сум | | + | |
| | Чойбалсан сум | | | + |
| | Чулуунхороот сум | | + | |
| | **Дүн** | **3** | **3** | **7** |
| **ДУНДГОВЬ** | Адаацаг сум | | | + |
| | Баянжаргалан сум | | | + |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | Говь-Угтаал сум | + | | |
| | Гурвансайхан сум | | | + |
| | Дэлгэрхангай сум | | | + |
| | Дэлгэрцогт сум | | + | |
| | Дэрэн сум | | | + |
| | Луус сум | | + | |
| | Өлзийт сум | | | + |
| | Өндөршил сум | | | + |
| | Сайхан-Овоо сум | | | + |
| | Хулд сум | | + | |
| | Цагаандэлгэр сум | | | + |
| | Эрдэнэдалай сум | + | | |
| | **Дүн** | **2** | **3** | **10** |
| **ЗАВХАН** | Алдархаан сум | | | + |
| | Асгат сум | | | + |
| | Баянтэс сум | | + | |
| | Баянхайрхан сум | | + | |
| | Дөрвөлжин сум | | + | |
| | Завханмандал сум | + | | |
| | Идэр сум | | + | |
| | Их-Уул сум | + | | |
| | Нөмрөг сум | | + | |
| | Отгон сум | | + | |
| | Сантмаргац сум | | + | |
| | Сонгино сум | | + | |
| | Тосонцэнгэл сум | | | НЭ |
| | Түдэвтэй сум | + | | |
| | Тэлмэн сум | | + | |
| | Тэс сум | | + | |
| | Ургамал сум | | | + |
| | Цагаанхайрхан сум | | | + |
| | Цагаанчулуут сум | | | + |
| | Цэцэн-Уул сум | | | + |
| | Шилүүстэй сум | + | | |
| | Эрдэнэхайрхан сум | | + | |
| | Яруу сум | | | + |
| | **Дүн** | **4** | **11** | **7** |
| **ОРХОН** | Жаргалант | | | + |
| | **Дүн** | | | **1** |
| **ӨВӨРХАНГАЙ** | Баруунбаян-Улаан сум | | | + |
| | Бат-Өлзий сум | + | | |
| | Баянгол сум | | | + |
| | Баян-Өндөр сум | | | + |
| | Богд сум | | + | |
| | Бүрд сум | | | + |
| | Гучин-Ус сум | | | + |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | Есөн зүйл сум | + | | |
| | Зүүнбаян-Улаан сум | | | + |
| | Нарийнтээл сум | | + | |
| | Өлзийт сум | | | + |
| | Сант сум | | | + |
| | Тарагт сум | | | + |
| | Төгрөг сум | | | + |
| | Уянга сум | + | | |
| | Хайрхандулаан сум | | + | |
| | Хархорин сум | | | НЭ |
| | Хужирт сум | + | | |
| | **Дүн** | **4** | **3** | **10** |
| **ӨМНӨГОВЬ** | Баяндалай сум | | + | |
| | Баян-Овоо сум | | + | |
| | Булган сум | | | + |
| | Гурвантэс сум | + | | |
| | Мандал-Овоо сум | | | + |
| | Манлай сум | | + | |
| | Ноён сум | | + | |
| | Номгон сум | | + | |
| | *Сэврэй сум* | | + | |
| | Ханбогд сум | + | | |
| | Ханхонгор сум | | | + |
| | Хүрмэн сум | | + | |
| | Цогт-Овоо сум | | + | |
| | Цогтцэций сум | + | | |
| | **Дүн** | **3** | **8** | **3** |
| **СҮХБААТАР** | Асгат сум | | | + |
| | Баяндэлгэр сум | | + | |
| | Дарьганга сум | | + | |
| | Мөнххаан сум | | + | |
| | Наран сум | | + | |
| | Онгон сум | + | | |
| | Сүхбаатар сум | | | + |
| | Түвшинширээ сум | | | + |
| | Түмэнцогт сум | | | + |
| | Уулбаян сум | | | + |
| | Халзан сум | | | + |
| | Эрдэнэцагаан сум | + | | |
| | **Дүн** | **2** | **4** | **6** |
| **СЭЛЭНГЭ** | Алтанбулаг сум | | + | |
| | Баруунбүрэн сум | | + | |
| | Баянгол сум | + | | |
| | Ерөө сум | + | | |
| | Жавхлант сум | | + | |
| | Зүүнбүрэн сум | | | + |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | Мандал сум | | | НЭ |
| | Орхон сум | | + | |
| | Орхонтуул сум | | | + |
| | Сайхан (Хөтөл)сум | + | | |
| | Сант сум | | | + |
| | Түшиг сум | | + | |
| | Хүдэр сум | | + | |
| | Хушаат сум | | | + |
| | Цагааннуур сум | | + | |
| | Шаамар сум | | | + |
| | Бугант тосгон | | + | |
| | Дулаанхаан тосгон | | | + |
| | Номгон тосгон | | | + |
| | Рашаант тосгон | | | + |
| | Түнхэл | | + | |
| | Хэрх тосгон | | + | |
| | **Дүн** | **3** | **10** | **8** |
| **ТӨВ** | Алтанбулаг сум | | | + |
| | Аргалант сум | | | + |
| | Архуст сум | | | + |
| | Батсүмбэр сум | + | | |
| | Баян сум | | | + |
| | Баяндэлгэр сум | | | + |
| | Баянжаргалан сум | | | + |
| | Баян-Өнжүүл сум | | | + |
| | Баянхангай сум | | | + |
| | Баянцагаан сум | | | + |
| | Баянцогт сум | | | + |
| | Баянчандмань сум | | + | |
| | Борнуур сум | | + | |
| | Бүрэн сум | | | + |
| | Дэлгэрхаан сум | | | + |
| | Жаргалант сум | | + | |
| | Заамар сум | | + | |
| | Лүн сум | | + | |
| | Мөнгөнморьт сум | | | + |
| | Өндөрширээт сум | | | + |
| | Сүмбэр сум | | | + |
| | Сэргэлэн сум | | | + |
| | Угтаалцайдам сум | | | + |
| | Цээл сум | | | + |
| | Эрдэнэ сум | | | + |
| | Эрдэнэсант сум | | + | |
| | **Дүн** | **1** | **6** | **19** |
| **УВС** | Баруунтуруун сум | + | | |
| | Бөхмөрөн сум | | + | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | Давст сум | | + | |
| | Завхан сум | | | + |
| | Зүүнговь сум | | + | |
| | Зүүнхангай сум | | + | |
| | Малчин сум | | | + |
| | Наранбулаг сум | | + | |
| | Өлгий сум | | | + |
| | Өмнөговь сум | + | | |
| | Өндөрхангай сум | + | | |
| | Сагил сум | | + | |
| | Тариалан сум | | + | |
| | Түргэн сум | | | + |
| | Тэс сум | + | | |
| | Ховд сум | | | + |
| | Хяргас сум | | | + |
| | Цагаанхайрхан сум | | | + |
| | **Дүн** | **4** | **7** | **7** |
| **ХОВД** | Алтай сум | | + | |
| | Булган сум | | | **НЭ** |
| | Буянт сум | | | + |
| | Дарви сум | | + | |
| | Дөргөн сум | | + | |
| | Дуут сум | | | + |
| | Зэрэг сум | + | | |
| | Манхан сум | + | | |
| | Мөнххайрхан сум | | | + |
| | Мөст сум | | + | |
| | Мянгад сум | | | + |
| | Үенч сум | | + | |
| | Ховд сум | | | + |
| | Цэцэг сум | | + | |
| | Чандмань сум | | + | |
| | Эрдэнэбүрэн сум | | | + |
| | **Дүн** | **2** | **7** | **6** |
| **ХӨВСГӨЛ** | Алаг-Эрдэнэ сум | | | + |
| | Арбулаг сум | | | + |
| | Баянзүрх сум | | + | |
| | Бүрэнтогтох сум | | | + |
| | Галт сум | | + | |
| | Жаргалант сум | | + | |
| | Их-Уул сум | + | | |
| | Рашаант сум | | | + |
| | Рэнчинлхүмбэ сум | | + | |
| | Тариалан сум | + | | |
| | Тосонцэнгэл сум | | + | |
| | Төмөрбулаг сум | | | + |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | Түнэл сум | | | + |
| | Улаан-Уул сум | + | | |
| | Ханх сум | | + | |
| | Цагааннуур сум | | | + |
| | Цагаан-Уул сум | + | | |
| | Цагаан-Үүр сум | | + | |
| | Цэцэрлэг сум | | + | |
| | Чандмань-Өндөр | | | + |
| | Шинэ-Идэр сум | | + | |
| | Эрдэнэбулган сум | | + | |
| | Хатгал тосгон /Алаг-Эрдэнэ сумын/ | + | | |
| | **Дүн** | **5** | **10** | **8** |
| **ХЭНТИЙ** | Батноров сум | | | + |
| | Батширээт сум | | + | |
| | Баян-Адарга сум | | | + |
| | Баянмөнх сум | | | + |
| | Баян-Овоо сум | | | + |
| | Баянхутаг сум | | | + |
| | Биндэр сум | + | | |
| | Галшар сум | | | + |
| | Дадал сум | | + | |
| | Дархан сум | | | + |
| | Дэлгэрхаан сум | | | + |
| | Жаргалтхаан сум | | + | |
| | Мөрөн сум | | | + |
| | Норовлин сум | | + | |
| | Өмнөдэлгэр сум | + | | |
| | Цэнхэрмандал сум | | | + |
| | Бор-Өндөр сум | | | НЭ |
| | Бэрх сум | + | | |
| | Өлзийт тосгон | | | + |
| | Хурх тосгон | | | + |
| | Тахилгат тосгон | | | + |
| | Хэрлэн Баян-Улаан тосгон | | | + |
| | **Дүн** | **3** | **4** | **14** |
| **УЛААНБААТАР** | Баянзүрх, Гачуурт тосгон | | | + |
| | Баянзүрх, Хонхор тосгон | | | + |
| | Хан-Уул,Туул тосгон | | | + |
| | Сонгинохайрхан, Жаргалант тосгон | | | + |
| | **Дүн** | | | **4** |
| | **Нийт** | **54** | **114** | **158** |
| | Сумын нэгдсэн эмнэлэг /НЭ/ | | | 6 |